

## ТӨВ БАНКНЫ РЕПО АРИЛЖААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 15 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор банкинд репо арилжаагаар санхүүжилт олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.2.1 “Төв банкны репо арилжаа” гэж Монголбанкнаас зарласан арилжаагаар банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцлээр банкинд санхүүжилт олгох нээлттэй захын үйл ажиллагааг хэлнэ.

1.2.2 “Худалдан авах үнэ” гэж худалдан авах өдөр репо хэлцлээр үнэт цаасаа худалдаж буй банкинд Монголбанкнаас төлж буй үнийн дүнг хэлнэ. Худалдан авах үнэ нь тухайн үнэт цаасны зах зээлийн үнээс эрсдэлийн хямдруулалтыг хассан дүнг байна.

1.2.3 “Буцаан худалдан авах үнэ” гэж энэ журмын 1.2.2-т заасан худалдан авах үнэ дээр үнийн зөрүүг нэмсэн дүнг хэлнэ.

1.2.4 “Үнийн зөрүү” гэж үнэт цаасыг буцаан худалдан авах үнэ болон худалдан авах үнийн зөрүүг бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$P_d = P_p * R_r * \frac{d}{360}$$

$$P_d = P_p * R_r * \frac{d}{365}$$

$P_d$  - Үнийн зөрүү

$P_p$  - Худалдан авах үнэ

$R_r$  - Репо хүү (жилийн)

$d$  - Репо санхүүжилтийн хугацаа

~~Үнийн зөрүүг бодөхдөө “бодит хуанлийн хонөг/360” гэсэн аргачлалыг хэрэглэнэ.~~

[Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар өөрчлөв.](#)

- 1.2.5 “Купонтой үнэт цаас” гэж хүүгийн тогтмол төлбөр нь үнэт цаасны хугацаа дуустал хоёр талын тохиролцсон хугацааны үе бүрт төлөгддөг үнэт цаасыг хэлнэ.
- 1.3 Репо хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны жагсаалтыг Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба (цаашид ЭУА гэх)-наас тодорхойлон гаргаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 1.4 Репо арилжаагаар олгох санхүүжилтийн харилцааг энэ журмаас гадна Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний холбогдох заалтаар зохицуулна.

### **Хоёр. Репо арилжаагаар олгох санхүүжилтийн үндсэн зарчим**

- 2.1 Монголбанкнаас зарласан репо арилжаанд дараах шаардлагыг хангасан банк оролцож болно:
- ~~2.1.1 Монголбанкнаас тогтоох заавал байлгах нооцийн шаардлагыг сүүлийн 3 сарын турш хангаж ажилласан;~~  
[МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А-118 дугаар тушаалаар хасав.](#)
- 2.1.2 Төлбөр тооцооны системд аливаа зөрчил гаргаагүй.
- 2.2 Худалдан авах үнэ, буцаан худалдан авах үнэ нь төгрөг, мөнгөөр илэрхийлэгдэнэ.
- 2.3 Тогтмол хүүтэй репо арилжааны хүүгийн хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- ~~2.4 Хүүгээр өрсөлдөх репо арилжааны хүүгийн доод хязгаар нь Монголбанкны Бөдлөгийн хүү байна.~~
- 2.4 Хүүгээр өрсөлдөх репо арилжааны хүүгийн доод хязгаарыг Төв банкны үнэт цаасны хүүгээр өрсөлдөх арилжааны хүүгийн дээд хязгаартай тэнцүү хэмжээгээр тогтоох.  
[МБЕ-ийн 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А-213 дугаар тушаалаар өөрчлөв.](#)
- 2.5 Репо арилжаагаар олгох санхүүжилт 7 хүртэл хоногийн хугацаатай байна.
- 2.6 Репо хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны эзэмших эрх шилжих нөхцөл нь эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан байна.
- 2.7 Монголбанк болон банк тухайн үнэт цаасны дугаар, төрөл, тоо ширхэг, жилийн хүүгийн хувь, эзэмших хоногийн тоо, худалдан авах өдөр, буцаан худалдан авах өдөр, худалдан авах үнэ, буцаан худалдан авах үнэ зэргийг тусгасан репо гэрээг

репо хэлцэл хийх бүрт “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний хавсралтын дагуу хийнэ.

2.8 Репо хэлцлийн гэрээний хугацаанд төлөгдөх купоны төлбөрийг худалдагч банк авах эрхтэй. Энэ нь зөвхөн купонтой үнэт цаасанд хамаарна.

2.9 Репо хэлцлээр Монголбанкинд худалдах Төв банкны үнэт цаас (цаашид ТБҮЦ гэх), Засгийн газрын үнэт цаас (цаашид ЗГҮЦ гэх)-наас бусад үнэт цаасны дуусах хугацаа нь буцаан худалдан авах өдрөөс хамгийн багадаа ажлын 3 өдрийн дараа байна.

### **Гурав. Репо арилжааг зохион байгуулах**

*Репо арилжаа явуулах шийдвэр гаргах*

3.1 Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх) репо арилжаа зарлах саналыг мөнгөний бодлогын зорилго, банкуудын мөнгөн хөрөнгийн нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглалд үндэслэн гаргана.

3.2 Репо арилжааг ямар хэлбэрээр явуулахыг Монголбанкны МБСГ-аас санал оруулсанаар Монголбанкны Ерөнхийлөгч репо арилжааны мэдэгдлээр батална.

*Репо арилжааны мэдэгдэл*

3.3 Монголбанкны Валют, эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх) батлагдсан репо арилжааны мэдэгдлийг 9:30 цагт Банк хоорондын цахим арилжааны систем (цаашид БХЦАС гэх)-ээр банкуудад хүргүүлнэ. БХЦАС-ээр хүргүүлэх боломжгүй тохиолдолд арилжааны мэдэгдлийг факсаар, эсвэл цахим шуудангаар хүргүүлж болно.

3.4 Арилжааны мэдэгдлийн бүрдүүлбэрт дараах мэдээллийг багтаасан байна:

3.4.1 Арилжааны огноо;

3.4.2 Арилжаа хийгдэх цаг болон санал хүлээж авах цаг;

3.4.3 Арилжааны дугаар;

3.4.4 Арилжааны хэлбэр;

3.4.5 Арилжаагаар олгох санхүүжилтийн хугацаа;

3.4.6 Буцаан худалдан авах өдөр;

3.4.7 Хэмжээ;

3.4.8 Хүүгийн доод хязгаар (хувиар илэрхийлсэн, зууны орны нарийвчлалтай, жилийн хүү).

*Репо арилжааг зохион байгуулах*

3.5 Монголбанкны ВЭЗГ репо арилжааг дуудлага худалдааны хэлбэрээр зохион байгуулна.

3.6 Репо арилжаа нь дараах хэлбэртэй байна:

3.6.1 Тогтмол хүүтэй, хэмжээг хязгаарлаагүй арилжаа;

3.6.2 Хүүгээр өрсөлдөх, хэмжээг хязгаарласан.

3.7 Монголбанк репо арилжааг Даваа гаригт явуулна. Хэрэв Даваа гариг нь нийтээр амрах баярын өдөр байвал дараагийн ажлын өдөр репо арилжааг явуулна.

3.8 Монголбанк банк хоорондын захад үүссэн таамаглах боломжгүй нөөцийн хэлбэлзлийг бууруулах зорилгоор Даваа гаригаас бусад гаригт репо арилжааг явуулж болно.

#### *Репо арилжааны санал*

3.9 Банк мэдэгдэлд дурьдсан цагт багтаан энэ журмын хавсралтаар баталсан загварын дагуу саналаа бэлтгэн БХЦАС-ээр дамжуулан Монголбанкны ВЭЗГ-т ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл бичгээр ирүүлнэ.

3.10 Монголбанк арилжааны саналын талаарх мэдээллийн нууцлалыг хадгална.

3.11 Хүүгээр өрсөлдөх репо арилжаанд банк ялгаатай хүүтэй 3 хүртэл санал ирүүлж болно.

3.12 Банк репо арилжаанд оролцох саналаа БХЦАС-д оруулан баталгаажуулсан бол уг саналыг өөрчлөх, цуцлах эрхгүй.

3.13 Монголбанк тухайн банкны энэ журмын шаардлагад нийцээгүй саналыг хүлээн авахаас татгалзаж болно.

3.14 Монголбанк энэ журмын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлсэн бол уг арилжаанд тухайн банкныг дахин санал ирүүлэхийг хориглоно.

#### *Санал хуваарилалт, арилжааны үр дүн*

3.15 Монголбанк банкуудаас ирүүлсэн шаардлага хангасан саналыг хүлээн авч дараах зарчмаар хуваарилалт хийнэ:

3.15.1 Энэ журмын 3.6.1-д заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан тохиолдолд банкуудын ирүүлсэн нийт саналаар хуваарилалтыг хийнэ.

3.15.2 Энэ журмын 3.6.2-т заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан тохиолдолд банкуудаас ирүүлсэн хүүгийн саналыг жагсаан, хамгийн өндөр хүүгийн санал өгсөн банкнаас эхэлж хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн банк ижил хүүгийн санал ирүүлсэн бөгөөд нийт саналын хэмжээ репо арилжааны зарласан хэмжээнээс давсан тохиолдолд 3.15.3-т заасан зарчмаар хуваарилалтыг хийнэ.

3.15.3 Репо арилжааны хувь тэнцүүлэн хийх хуваарилалтыг дараах томъёогоор тооцно.

$$P = B * \frac{V2}{V1}$$

*P - Тухайн банкинд хуваарилагдах хэмжээ*

*V1 - Банкуудын ирүүлсэн нийт саналын хэмжээ*

*V2 - Тухайн банкны ирүүлсэн саналын хэмжээ*

*B - Монголбанкнаас зарласан нийт хэмжээ*

3.16 Монголбанкны ВЭЗГ БХЦАС-ээр дамжуулан Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т гүйлгээний шийдвэрийг илгээсэнээр гүйлгээ хийгдэнэ.

3.17 Монголбанкны ВЭЗГ “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний хавсралтын дагуу санал нь амжилттай биелсэн банктай репо гэрээ байгуулж, гэрээний нэг хувийг Монголбанкны ТТБГ-т хүргүүлнэ.

3.18 Монголбанк репо арилжаа явагдаж дуусмагц арилжааны нийт үр дүнг БХЦАС-ээр дамжуулан банкуудад мэдэгдэнэ. Банк тус бүрийн үр дүнг зөвхөн тухайн банкинд нь мэдэгдэнэ. Энэ журмын 3.6.1-д заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан тохиолдолд арилжааны үр дүн нь арилжаанд ирсэн нийт санал болон хүлээн авсан саналын дүнг тусгасан байна. Энэ журмын 3.6.2-т заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан тохиолдолд арилжааны үр дүнд дээрх мэдээллээс гадна жигнэсэн дундаж хүү, хамгийн их болон бага хүү зэргийг тусгасан байна.

*Репо арилжааг цуцлах*

3.19 Монголбанк техникийн саатал, арилжаанд оролцогчдын хуйвалдаан, бусад шалтгаанаар арилжааг дангаар цуцлах эрхтэй. Монголбанк санхүүгийн зах зээлийн зарчим, шударга ёсыг баримтлах бөгөөд арилжааг цуцалсан шалтгааныг тайлбарлахгүй байж болно.

3.20 Монголбанк репо арилжааг цуцалсан тохиолдолд дараагийн арилжаа явагдах огноо, цагийг банкуудад мэдэгдэнэ.

## **Дөрөв. Репо арилжаагаар олгох санхүүжилтийн бүртгэл**

- 4.1 Төв банкны репо арилжаагаар олгох санхүүжилтийн нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан, хүчин төгөлдөр мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хийнэ.
- 4.2 Гэрээнд заасан худалдан авах өдөр Монголбанк худалдагч банкны дансанд худалдан авах үнийн дүнг шилжүүлэх, худалдагч банк эзэмшиж буй үнэт цаасаа Монголбанкинд шилжүүлэх гүйлгээ нэгэн зэрэг хийгдэнэ. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд репо хэлцэл хийсэн өдөрт багтаан хийнэ.
- 4.3 Гэрээнд заасан буцаан худалдан авах өдөр худалдагч банк буцаан худалдан авах үнийг, Монголбанк үнэт цаасыг буцаан шилжүүлэх гүйлгээ нэгэн зэрэг хийгдснээр репо хэлцэл дуусгавар болно. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах өдөрт багтаан хийнэ.
- 4.4 Репо хэлцлээр хүлээсэн үүргийг аль нэг тал биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний 5.2-т заасан хариуцлагын арга хэмжээг авна.
- 4.5 Монголбанкны ТТБГ репо арилжаагаар олгосон санхүүжилтийн үлдэгдлийг өдөр бүрийн банкуудтай хийх өглөг, авлагын тайланд тусгана.

### **Тав. Бусад**

- 5.1 Энэ журмын заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.2 Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТӨВ БАНКНЫ РЕПО АРИЛЖААНД ОРОЛЦОХ САНАЛЫН ХУУДАС

... оны ... сарын ...-ний өдөр

Арилжааны дугаар ...

1. Банкны нэр:
2. Репо хэлцэл хийх үнэт цаасны нэр, төрөл, дугаар:
3. Репо хэлцэл хийх үнэт цаасны нэрлэсэн үнэ:
4. Репо хэлцэл хийх үнэт цаасны хугацаа (хоногоор):
5. Үнэт цаасны анхдагч зах дээр арилжаалагдсан огноо:
6. Үнэт цаасны хугацаа дуусах огноо:
7. Тухайн банкны уг үнэт цаасыг эзэмшсэн хоног:
8. Арилжаанд оролцох хэмжээ:
9. Хүүгийн санал (Хүүгээр өрсөлдөх арилжааны үед):

Банкийг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг: .....(гарын үсгийн тайлал)  
(тамга)

Санал хүлээн авсан Монголбанкны ажилтан: ..... (гарын үсгийн тайлал)

Санал хүлээн авсан цаг минут: